1. ЦЭС -> "Эхний үлдэгдэл оруулах" гэж орно.



2. "Эхний үлдэгдэл оруулах" цонх нээгдэнэ. Хэрэв та "Барааны нэр төрөл" модульд Барааны сангаа бүрэн оруулаагүй бол санаа зовох хэрэггүй. Энд бүртгэсэн бараа шууд цааш Барааны сан болж хадгалагдана.

З	Эхний үлдэгдэл оруулах — 🗆 🗙											
	Эхний үлдэгдэл оруулах огноо: 2014-12-31 🔻 🗌 Хайлтын мөр харуулах											
								Цааш хадгалах хэсэг				
				Ерөнхий мэдээлэл								
	Ангилал	Дотоод код	БАРКОД	Барааны нэр	Too.x	Зарах үнэ	Авдаг үнэ	Нэгж	Заавал байх үлдэгдэл	Үйлдвэрлэгч		
Ø.	Зайлшгүй шаар	3800714540321	3800714540321	Азатрил хөвм 100 мг 5мл, Акт	24	21,000	6,960	фл	0		*	
	Зайлшгүй шаар	3800714504644	3800714504644	Азатрил хөвм 200 мг 5мл, Акт	42	25,000	9,000	фл	0		U	
	Зайлшгүй шаар	8656020823123	8656020823123	Азитромицин капс 250мг N10, Инц	34.5	8,000	5,400	ш	0			
	Бусад	3800009121587	3800009121587	Актавит сироп 100мл, Акт	5 3	5,000	4,800	фл	0			
	Бусад	8806417011514	8806417011514	Аллком шахм 500мг N4, Солонгос	6	3,600	2,160	ш	0			
	Зайлшгүй шаар	3800009121013	3800009121013	Алмагель А хөвм 170мл, Акт	12	7,500	2,520	фл	0			
	Зайлшгүй шаар	3800009121112	3800009121112	Алмагель НЕО с/шин 170мл, Акт	6	6,000	2,520	фл	0			
	Зайлшгүй шаар	3800009121075	3800009121075	Алмагель хөвм 170мл, Акт	24	4,200	2,520	фл	0			
	Зайлшгүй шаар	4602676003390	4602676003390	Амитриптилин шахм 25мг N10, Бусад	106.5	1,000	600	ш	0			
	Зайлшгүй шаар	4031571051197	4031571051197	Амло денк шахм 10мг N10, Денк	814.599	7,500	18,000	ш	0			
	Зайлшгүй шаар	4031571051166	4031571051166	Амло денк шахм 5мг N10, Денк	146.001	4,300	9,720	ш	0			
	Зайлшгүй шаар	8656020989317	86560209893/7	Амоксициллин 0,25мг N10, Монос	4.5	1,500	900	ш	0		-	
	2 149 m 3				17,021.824							
4											Þ	
🕂 Бэлэн жагсаалтаас нэмэх (Ctrl+N) + - 🗸 Батлах [Hoopor]												

- "+" нэмэх тэмдэгтэй товчийг дарж шинэ мөр нэмээд тэндээ excel дээр шивж байгаа мэт бараагаа шууд шивнэ. "Too.x" талбарт оруулсан тоо нь тухайн барааны эхний үлдэгдэл болох юм.
- 2) "Бэлэн жагсаалтаас нэмэх" товчийг дарж манайхаас бэлдэж өгсөн эмийн жагсаалтаас татаж болно. Ингэснээр та барааны нэр, баркод бүртгэх үйлдлийг хөнгөлнө. Гэхдээ Ангилал, Тоо.х, Зарах үнэ, Авдаг үнэ, Нэгж гэсэн үлдсэн талбаруудыг гараараа заавал бүртгэх ёстойг анхаарна уу. Мөн баркод буруу орж ирж болох тул заавал шалгаж байна уу.

Хүснэгт дээр бараа бүртгэх явцад баазруу хадгалахад алдаа гарсан бол хүснэгтийн төгсгөл дэх "Хадгалагдсан эсэх", "Алдаа гарсан бол ..." гэсэн багануудад энэ тухай дэлгэрэнгүй харагдана. Доорхи зурагт харуулав.

			- 6 0	- U A				
				Excel -c татах				
	Нийт үнэ							
рах үнэ	Нийт авдаг үнэ	Нийт ашиг	Хадгалагдсан эсэх	Алдаа гарсан бол 				
504,000	167,040	336,95	D Хадгалагдсан					
,050,000	378,000	672,0	0 Хадгалагдсан					
276,000	186,300	89,70	0 Хадгалагдсан					
15,000	14,400	Ð	0 Хадгалагдсан					
21,600	12,960	8,6 <mark>1</mark>	0 Хадгалагдсан					
90,000	30,240	59,75	0 Хадгалагдсан					
36,000	15,120	20,8 <mark>3</mark>	0 Хадгалагдсан					
100,800	60,480	40,3 <mark>2</mark>	0 Хадгалагдсан					
106,500	63,900	42,6 <mark>0</mark>	0 Хадгалагдсан					
09,492.5	14,662,782	-8,553,28	5 Хадгалагдсан					
27,804.3	1,419,129.72	-791,325 4	2 Хадгалагдсан					
6,750	4,050	2,70) Хадгалагдсан					
7,472.65	76,667,964.5	17,679,508.1	5					

- 3) **"Батлах"** товчоор эхний үлдэгдлээ батлана. Бүх бараагаа бүртгэж дууссан үедээ л батлах ёстойг анхаарна уу.
- 4) Хэрэв танай барааны бүртгэл ехсеl файлаар бэлэн байгаа бол "Excel -c татах" товчоор уг файлаа татаж, нэг бүрчлэн шивэх ажлыг хөнгөвчилж болно. Хэрэв Excel -с татах бол та нар өөрсдөө татаж болохгүй, заавал манай ажилтнаас тусламж заавар авах ёстой шүү!
- 5) Хүснэгт дээр барааг бүртгэхдээ Ангилал баганаас Нэгж багана хүртэл нэг ч талбар орхихгүй бүртгэх ёстойг анхаарна уу. Аль нэг талбарыг хоосон орхивол цааш баазруу орохгүй! Эдгээр талбараа бүрэн бүртгэсэн бол "+" мөр нэмэх товчийг дарахад өмнөх мөр нь хадгалагдана.

Анхаарах зүйлс:

- 1) Эхний үлдэгдлийг тооллого хийнгээ бүртгэх нь хамгийн зөв.
- Эхний үлдэгдэл гэдэг бол орион програмыг ашиглаж эхлэх үед танайд байсан эм барааны үлдэгдлийг л хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл програмыг 24 оны 8 сарын 20 -нд суулгуулсан бол 20 -ны үлдэглийг л эхний үлдэгдэл гэнэ.
 - а. Борлуулалтаа програм дээр хийж эхлэхээс өмнө эхний үлдэгдлээ оруулах ёстой.
 - b. Тооллого хийнгээ 1 өдөрт оруулж дуусгах хэрэгтэй, ихдээ 2 өдөрт оруулна.
 - с. Хэрэв өөр програм ашигладаг байж байгаад Орион авсан бол тэр програмаасаа бараагаа татуулж болно. Үүний тулд манай ажилтанруу холбогдоорой.
 - d. Эхний үлдэгдлээ оруулаад дууссан бол Батлаад хаана. Түүнээс хойш эм бараа бөөний төвөөс ирвэл "Татан авалт" модулиар орлого авна. Эхний үлдэгдэл дээрээ нэмэхгүй шүү, үүнийг хатуу хориглоно.

- 3) Хадгалах товч байхгүйг анзаарсан байх. Нэг бараагаа Ангилал талбараас Нэгж хүртэл бүрэн бүртгэсний дараа "+" товч дарж шинэ мөр нэмэх үед өмнөх мөр нь хадгалагдана. Хэрэв Ангилалаас Нэгж хооронд талбар хоосон орхивол хадгалагдахгүй, алдаа зааж улайна гэдгийг анхаарна уу. Харин Нэгжээс хойшхи талбарууд дундаас та хүсвэл Дуусах хугацааг бүртгэж болно, бусад нь шаардлагагүй.
- 4) Барааны нэр дээр, хэрэв эм бол эмийн Нэр, Тун хэмжээ, Савлалтыг заавал бичнэ. Жишээ нь "Ибупрофен 400мг №10" гэх маягаар.
- 5) Барааны нэр давхардах ёсгүй. Хоёр өөр бараа заавал нэрээрээ ялгарах ёстой. Хэрэв эмийн нэр, тун, савлалт ижил бол үйлдвэрлэгчийг нь араас нь залгаж бичнэ. Жишээ нь "Ибупрофен 400мг №10 Монос" гэх маягаар. Эсвэл улсын нэрийг бичсэн ч болно. Хоёр эм юугаараа ялгарч байна, түүнийг нь нэр дээр заавал бичнэ шүү. Ингэснээр дараа нь та нарт л ойлгомжтой байх болно.
- 6) Ширхэгээр оруулах уу, эсвэл Бүхлээр буюу хайрцагаар нь оруулах уу? Хэрэв тухайн эмийг хаяа ч болов ширхэгээр зардаг бөгөөд савлалтдаа 30, 28, 14, 7 гэх мэт 5д хуваагдахгүй ширхэгтэй бол Ширхэгээр бүртгэсэн нь дээр.
- Ширхэгээр бүртгэнэ гэж яахыг хэлж байна? Ерөөсөө л Зарах үнэ дээрээ ширхэгийн үнэ оруулахыг Ширхэгээр бүртгэх гэж хэлж байгаа юм.
- 8) Ширхэг эсвэл бүхлийн алинаар бүртгэсэнг яаж мэдэх вэ? Эцсийн эцэст Зарах үнэ л үүнийг хэлнэ. Хүмүүс барааны нэр, хэмжих нэгжийг яаж ч бүртгэсэн байж болох ба эдгээрээс үл хамааран Зарах үнийг л харах ёстой шүү. Жишээ нь "Ибупрофен денк 400мг" -н үнэ 450 төгрөг бол энэ нь ширхэгээр бүртгэснийг харуулж байна. Харин 4,500 төгрөг байвал Трүпээр бүртгэсэн байна гэсэн үг юм.
- 9) Хэрэв бүхлээр бүртгэсэн эмийг дараа нь ширхэгээр зарах хэрэг гарвал бутархай тоо оруулж зарж болно. Жишээ нь "Ибупрофен денк 400мг" -г 4,500 төгрөг гээд трүпээр бүртгэсэн үед 3 ширхэгийг зарах бол 0.3 гэсэн бутархай тоо оруулж зарна.
- 10) Зарах үнийг ширхэгээр оруулсан эсэхээс хамаарч "Тоо.х" болон "Авдаг үнэ" -ээ уялдуулж хөрвүүлж оруулна. Жишээ нь зурагт харуулснаар Пирацетам 200мг -н үнэ 400 төгрөг буюу ширхэгээр байна. Ийм үед Тоо.х талбарт ширхэгрүү хөрвүүлсэн тоо тавина. Хэрэв бүхлээр буюу 4,000 гэсэн үнэ оруулсан бол тоо хэмжээ нь 0.6 гэсэн бүхэлрүү хөрвүүлсэн тоо байх ёстой. Хүмүүс ингэж тоогоо хөрвүүлэхийг дандаа мартдаг тул үүнийг сайн анхаараарай.

Ангилал	Дотоод код	БАРКОД	Барааны нэр 🔺	Too.x	Зарах үнэ	Авдаг үнэ	Нэгж	Заавал үлдэ
Бусад	3800712045316	3800712045316	Пирамем капс 400мг N10, Акт	121.8	1,400	840	ш	
Зайлшгүй шаар	4601969000047	4601969000047	Пирацетам акр 400мг N10,	219	1,200	840	ш	
Зайлшгүй шаар	4602824009687	4602824009687	Пирацетам шахм 200 мг N10, Мосхим	6	400	240	u	
Зайлшгүй шаар	4600828001348	4600828001348	Преднизолон шахм 5мг N10, Мосхи	12	400	240	ш	

- 11) Хүснэгтэд байгаа "Савлалт дахь тоо" талбарын утгыг 1 хэвээр нь үлдээнэ. Хэрэв савлалтын тоо оруулахыг хүсвэл эхлээд үүний сул болон давуу талыг манай ажилтнаас асууж лавлах хэрэгтэй.
- 12) Эцэст нь, эхний үлдэгдлийг шивж дууссан хойноо ямар үед эргэж ороод засаж болох вэ? Зөвхөн, эхний үлдэгдэл шивэхдээ буруу шивсэн зүйл дараа нь илэрсэн ганц тохиолдолд л

эргэж ороод засаж болно. Хүмүүсийн түгээмэл гаргадаг алдаа бол, эхний үлдэглээс хойш гарсан өөрчлөлтийг эхний үлдэгдэлрүү орж хийдэг явдал юм. Жишээ нь, 24 оны 8 сарын 20 нд эхний үлдэгдлээ шивж дууссан гэж бодьё, дараа нь 24 -нд нэг барааны үнэ өөрчлөгдсөн байг, ийм үед барааны үнийг "Барааны нэр төрөл" -рүү орж л өөрчлөнө, харин эхний үлдэгдэлрүү орж зарах үнэ өөрчлөхийг хатуу хориглоно. Ийм зүйл хийж байгаа бол та эхний үлдэгдэл гэдэг зүйлээ агуулгын хувьд огт ойлгоогүй байгаа гэсэн үг юм. Програм доторхи аливаа бүртгэл бүгд тухайн цаг мөчөөсөө хойш үйлчилдэг. Тиймээс, 24-нд гарсан өөрчлөлтийг 20-нд буюу 4 хоногийн өмнөх эхний үлдэгдэлрүү очиж засаж болохгүй.